

Орон сууцны үнийн мэдээнд хамрагдах аж ахуйн нэгж нь үл хөдлөх хөрөнгийн зах зээлд арилжаалагдсан дэд бүтэц (цахилгаан, дулаан, усан хангамж, бохир)-ийн төвлөрсөн холболттой орон сууцны талаарх мэдээллийг маягтын дагуу үнэн зөв гаргаж, тогтоосон хугацаанд мэдээлнэ. Мэдээллийг зөвхөн орон сууцны зах зээлийн үнийн индексийг тооцоход ашиглана.

Маягтад тухайн сард худалдагдсан бүх орон сууцны худалдан авагчийн үнийг сар бүрийн 30-наар эцэслэж бүртгэнэ.

“Статистикийн тухай” Монгол Улсын хуулиас...

“Статистикийн мэдээлэгч” гэж статистикийн мэдээлэл, судалгаанд хамрагдсан, Монгол улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг, өмчийн бүх төрөлд хамаарагдах хуулийн этгээд, гадаадад үйл ажиллагаа явуулдаг Монгол Улсын хуулийн этгээд, Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг хэлнэ.

Хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дугаар заалт: Мэдээлэгч нь статистикийн мэдээлэл, судалгаа гаргахад шаардагдах анхдагч бүртгэл хөтлөх; 6 дугаар заалт: Статистикийн мэдээлэл, судалгааг батлагдсан буюу зөвшөөрөгдсөн үзүүлэлт, аргачлалын дагуу тогтоосон хугацаанд үнэн зөв гаргаж өгөх; 9 дүгээр заалт: Албан ёсны статистик мэдээллийг энэ үйл ажиллагааг эрхэлдэг холбогдох байгууллагад өөрийн зардлаар хүргэх үүрэгтэй.

Хуулийн 22 дугаар зүйлийн 3 дугаар заалт: Албан ёсны статистикийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын ажилтан албан ёсоор мэдээлэх түвшинд хүрээгүй статистикийн мэдээлэл, судалгааны дүн, төрийн болон аж ахуйн нэгж, байгууллага, иргэний нууцад хамаарах мэдээллийг нийтэд задруулахыг хориглоно.

МАЯГТЫГ НӨХӨХ ЗААВАР

Хаягийн хэсэг

Маягтын хаягийн хэсэг нь ҮСХ-ны бизнес регистрийн санд өөрчлөлт, баяжилт хийхэд чухал ач холбогдолтой мэдээлэл юм. Тухайн аж ахуйн нэгж нь өөрийн нэр болон регистрийн дугаарыг улсын бүртгэлийн гэрчилгээг үндэслэн үнэн зөв нөхнө. Хаягийн хэсгийн мэдээлэлд оршин байгаа нийслэл, дүүрэг, үйл ажиллагаа явуулж байгаа салбарын чиглэл зэргийг нөхөж бичнэ. Кодыг ҮСХ-ны ажилтнууд нөхнө.

I. Нийтийн орон сууцны үнийн мэдээлэл

Тодорхойлолт: Нийтийн орон сууцны байшин гэж зориулалтын зураг, төслөөр баригдсан, бүтэц хийцийн хувьд бүхэлдээ буюу ихэнхи хэсэг нь дөрөв ба түүнээс дээш сууцны зориулалттай төхөөрөмжлөгдсөн (байшингийн хэмжээ, давхар, хэдэн айл суух зориулалттайгаас үл хамааран), дэд бүтцийн хангамжтай байшинг хэлнэ.

Орон сууцны байршил, хаяг, дугаар буюу А баганад: Тухайн орон сууцны оршин байгаа дүүрэг, хороо, хороолол болон хотхоны нэр, байрны дугаарыг тодорхой бичнэ. Жишээ нь: Баянгол дүүргийн 7-р хороо, 4-р хороолол, 30-р байр 45 тоот.

Барилгын ханын хийц буюу Б баганад: Тухайн орон сууцны барилгын ханын үндсэн хийцийн материалын нэрийг бичнэ. Үүнд: тоосго, каркас, угсармал.

1-р баганад: Худалдагдсан сууцны давхрын дугаарыг тавина. Жишээ нь: Худалдагдсан орон сууц 3 дугаар давхарт орших бол 3 гэж нөхнө.

2-р баганад: Гал тогооны өрөөнөөс бусад зочны болон унтлагын өрөөг оруулах бөгөөд шинэ сууцны хувьд гал тогооны өрөө нь тусдаа биш, зочны өрөөтэй хамтдаа бол өрөөний тоог "нэг" гэж үзэж, бусад өрөөг нэмж бичнэ.

3-р баганад: Гал тогоо, ариун цэврийн өрөө, корридорын талбайг оруулсан сууцны нийт талбайн хэмжээг нөхнө. Жишээ нь: 2 өрөө байрны хувьд зочны өрөө 16 м², унтлагын өрөө 12 м², гал тогооны өрөө 8 м², ариун цэврийн өрөө 2 м², корридор 3 м² бол сууцны нийт талбайн хэмжээ нь 41 м² болно.

4-р баганад: Үнийн дүнг мянган төгрөгөөр, таслалаас хойш нэг оронтойгоор бичнэ. Жишээ нь: 35880.0 мянган төг гэх мэт. Орон сууцны үнэ гадаад валютаар (ам.доллар) илэрхийлэгдсэн тохиолдолд Монгол банкны тухайн өдрийн ханшаар тооцож, төгрөгт шилжүүлж дүнг бичнэ.